



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/97

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн Онцгой байдлын
хэлтсийн данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл
хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдаагаар худалдсан 35,000,000 (гучин таван сая) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Киа Хио маркийн 65-50 УНК, 5,930,000 (таван сая есөн зуун гучин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Зил-131 маркийн 52-14 УБХ улсын дугаартай тээврийн хэрэгслүүдийг данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Д.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Д.Бат-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (П.Магнайбаатар)-т тус тус даалгасугай.

ДАРГА



М. БАЯРАА

115050000275